

Алтны үйлдвэрлэл

1. Алтны шинж чанар. *Aurum* буюу *Үүрийн туяа* гэсэн утгатай Латин үгнээс гаралтай. Алт нь байгаль дээр цэврээр (дангаараа) орших ба хувийн жин ихтэй (хүнд), зөөлөн, гялалзсан шар өнгөтэй металл юм. Байгальд маш ховор тохиолдолд 6; 8; 12; ханатай талст хэлбэрээр оршдог. Ихэнхдээ байгальд нунтаг тоос, үйрмэг, нимгэн хуудас, нарийн үслэг төрхтэйгээр мөн газрын давхаргад судал, бусад металл болон чулуулагтай холимог хадан тогтцын хэлбэртэйгээр оршдог.



Алтны нягт $19,3 \text{ г/см}^3$, хайлах температур $1064 \text{ }^\circ\text{C}$ байдаг. Цул хадан болон хавтан хэлбэрээр хэзээ ч оршдоггүй гэж үздэг. Алт нь уян хатан, давтагдах, сунгагдах, цутгагдах өвөрмөц чанартай бөгөөд дулаан цахилгааныг маш сайн дамжуулдаг.

Алтны хамгийн онцгой чанар нь ус болоод агаарын нөлөөнд автаггүй, бараг бүх төрлийн хүчлийн үйлчлэлд тэсвэртэй юм. Алт озонтой давсны хүчилд урвалд орон Au_2 нэгдлийг үүсгэх ба цианы уусмалд задарч Au_4 нэгдлийг үүсгэдэг учир алтыг ялган авахад цианы хүчлийг зарим нөхцөлд хэрэглэдэг. Алт нь ихэнхи тохиолдолд 30-50 % ийн мөнгөний хольцтой байдаг. Үүнээс гадна түүний найрлагад зэс төмөр зэрэг зарим эрдэс бага хэмжээтэй байна.

Үндсэн ордоос алтны зэрэгцээгээр мөнгө, теллур, висмут, хүнцэл зэргийг олборлодог. Алтны зарим шороон орд нь Доржпалам, уулын болор, цагаан алт, титаны бүлгийн эрдэс агуулдаг. Цэвэр алтны агуулгыг сорьц гэх бөгөөд хэрэв алтны сорьц 900 гэвэл тэр нь түүний найрлагад цэвэр алт 90% байна гэж үзнэ. /Алт [1]/.

2. Алтны хэрэглээ. 2009 он хүртэл хүн төрөлхтөн алтны үндсэн ба шороон ордоос 1800000 тонн алт олборлоод байна. Алт нь түүхийн туршид, үнэт металл гэж тооцогдон арилжааны хэрэгсэл, хадгаламж, гоёл чимэглэлд өргөн хэрэглэгдсээр ирсэн ба орчин үед шүдний эмнэлэг, электроникийн салбарт багагүй хэмжээгээр ашиглагдаж байна. Нянгийн эсрэг үйлчилгээ үзүүлдэг учир эмнэлэгт хэрэглэнэ. Алт нь янз бүрийн металлтай холилдох чадвар маш өндөр бөгөөд энэ чанарыг нь ашиглан төрөл бүрийн үнэт хайлшийн үндсэн эд болгон хэрэглэдэг юм.

Алтыг гоёл чимэглэлээс эхлэн пуужин, цөмийн тогоо, нисэх онгоц, холбоо харилцааны техник хэрэгсэл, хими, анагаах ухааны салбар, фото зургийн үйлдвэр, зэрэг олон төрлийн салбарт хэрэглэдэг.

Монголчууд эрт дээр веес алтаар гангарч ирсэн ард түмэн бөгөөд Бүр Хүннүгийн веес алтаар маш нарийн донж хийцтэй эдлэл хийж хэрэглэж байсныг эрдэмтэд тогтоосон байна. Алтыг бас Дорно дахины анагаах ухааны салбарт олон зууны тэртээгээс ашиглаж ирсэн гэсэн баримт буй.

3. Алтыг баяжуулах тухай. [6]. Алт нь байгаль дээр үндсэн ба шороон орд гэсэн 2 янзаар оршино. Үндсэн ордыг анхдагч орд ч гэж нэрлэх ёс бий. Үндсэн ордын алт нь голдуу болортой, холилдож, нарийн шигдээс хэлбэрээр болорын талстын завсар хоорондуур нимгэн наалдас, эрдсийн талстуудын завсраар нарийхан утас маягтай тогтсон байдаг. Олон мянган жилийн турш байгалийн хүчний нөлөөгөөр явагдсан хувирал өөрчлөлтийн үр дүнд анхдагч ордын тодорхой хэсэг бутран нунтаглагдаж, байгалийн "хөдөлгөөнд" орсны эцэст хоёр дахь орд буюу шороон ордыг үүсгэдэг.

Алтны хүдрийг ашиглалт явуулах аргаас нь хамаарч: Шижирмэг алтны хүдэр буюу шороон орд, исэлдсэн хүдэр буюу ил уурхай, үндсэн хүдэр буюу далд уурхай гэж анилна.

Ер нь алтны ширхэгийн хэмжээ бол түүний технологийн гол үзүүлэлтийн нэг билээ. Шороон ордыг ашиглахад хялбар төсөр байдаг учраас алтны агуулга 0.1 г/тн-оос багагүй бол олборлох боломжтой гэж үздэг. Харин үндсэн ордын алт нь 1-4 г/тн-оос багагүй бол олзворлох нөхцөлтэй байдаг. Шороон орд нь харьцангуй гүн биш байрладаг. Иймд илүү хямд аргаар ашиглах боломжтой. Ер нь шороон ордны алтыг олборлох нь үндсэн ордынхыг бодвол 10 дахин хямд байдаг.

Эрдэс түүхий эдээс алт ялгах маш олон хувилбар байх бөгөөд дараах үзүүлэлтээс хамаарч технологийн шийдэл өөр өөр байдаг:

- Тухайн ордын алтны ширхэгийн хэмжээ
- Алт агуулсан хүдрийн химийн найрлага
- Алт наалдсан эрдсийн шинж чанар (кварц, хүхэрлэг хүдэр) болон технологийн процессыг хүндрүүлэх бусад хүчин зүйл.

Алт ялгах технологийн процесст хүдрийг бэлтгэх (нунтаглах, жижиглэх, шигшиж ангилах), баяжуулах (жингийн ба хөвүүлэн баяжуулах), металлургийн боловсруулалт (мөнгөн усаар амальгамжуулах, циан болон тиокарбамидийн уусмалд уусгах, хайлуулах, шатаах), зэрэг үйлдлүүд хамаарагдана.

Алт олзворлоход аль болох алтаа бүрэн ялгахад гадна материалын болоод эрчим хүчний зарцуулалт бага байхаар технологийн горимоо бодолцох ёстой.

Хүдрийг бэлтгэх хүрээнд түүнийг бутлах, нунтаглах, шигших, ангилах үйл ажиллагаа багтдаг. Алтны ширхэг хэдий чинээ жижиг байна төдий чинээ сайн нунтаглаж жижиглэх шаардлагатай. Харьцангуй том хэмжээний алттай хүдрийг 0.4 мм (90%) хэмжээгээр нунтаглана. Том жижиг янз бүрийн хэмжээтэй хүдрийг 0.074 мм, үлэмж жижиг ширхэглэлтэй бол 0.044 мм-ээр нунтаглана.

Манайд алтны хүдрийг баяжуулахад гол төлөв жингийн аргыг хэрэглэдэг.

Алтыг жингийн аргаар ялгах: Үнэт металлууд нь түүнийг дагалдан оршдог бусад элементүүдтэй харьцуулахад нягт ихтэй, харьцангуй хүнд жинтэй учраас жингийн аргаар үнэт металлыг ялгах технологийн өргөн хэрэглэгддэг. Алтны ихэнх хүдэр нь 0.1 мм хэмжээтэй шижиур алт агуулах ба тийм алтыг хөвүүлэх буюу уусгах аргаар ялгахад бэрхшээлтэй, зардал ихтэй байдаг. Тийм учраас урьдчилан жингийн аргаар ялгаж баяжуулах шаардлагатай. Орчин үед үндсэн ордын алтыг ялгахад дараах жингийн аргуудыг ашигладаг.

-Агаарын урсгалаар баяжуулах

-Тунгаах машинд баяжуулах

-Зөөлөн бүрхэвчтэй шлюз ашиглаж баяжуулах

-Концентраци нэмэгдүүлэгч чичрүүлэгч шүүгээ ашиглах

-Барбантай концентратор ашиглах

-Богино конустай гидроциклоны тус тус ашиглана.

Алтны хөвүүлэн баяжуулах технологи: Алтны хүдрийг хөвүүлэх аргаар баяжуулах боломж нь тухайн хүдэр чухам ямар хэлбэртэй эрдсүүдээс тогтож байгаагаас хамаарч технологийн өөр өөр шийдэл шаардагдана. Хөвүүлэн баяжуулах аргыг цианжуулан уусгах боломжгүй, баяжигддаггүй хүдрийг боловсруулахад хэрэглэх боловч нийт металл авалтын хэмжээ төдийлөн хангалттай биш байх нь нилээд ажиглагддаг. Гэвч ердийн өргөн хэрэглэгддэг аргуудыг хэрэглэх боломжгүй тохиолдолд хөвүүлэх аргаар баяжуулахад арай л хямд байна.

Алтны хүдрийг амальгамжуулах тухай: Эрдэс хүдрийг мөнгөн усаар үйлчилж үнэт металл ялгах аргыг амальгамжуулах гэнэ. Үнэт металлууд мөнгөн усанд хялбархан уусаж, мөнгөн усаар норгогдож металл-мөнгөн ус гэсэн өвөрмөц нэгдэл үүсгэнэ.

Жингийн болоод амальгамын аргаар зөвхөн харьцангуй томхон ширхэгтэй алтыг ялгаж болно. Гэтэл алт агуулсан хүдрийн ихэнхэд дээрх аргаар ялгаж болдоггүй жижиг ширхэгтэй


алт байх ба түүнийг зөвхөн цианжуулан уусгах аргаар ялган авч болно. Алтыг цианжуулж ялгахдаа нуруулдан уусгах технологийг хэрэглэх нь элбэг байдаг.

Цианд ууссан алтыг металл цайраар "цементациан" ялган тунадасжуулах буюу аль эсвэл ион солигч давирхай, идэвхжүүлсэн нүүрсээр шингээн ялгадаг. Алт шингээн авсан нүүрсийг баяжсан нүүрс гэх ба үйлдвэр рүү тээвэрлэж тэнд десорбцийн процесст оруулан алтыг ялган авна.

Шороон ордын алт олборлох гол технологи нь усаар урсган, бусдаасаа хүнд жинтэй алт нь саад, хаалтанд тээглэн үлдэх, тунах хэлбэрээр ялгагддаг. Шороог усаар зайлж алтыг нь тунгаах авах энэ арга нь химийн ямар нэгэн бодис хэрэглэдэггүйгээрээ байгальд хоргүй гэж үнэлэгддэг. Гэхдээ шороон ордны ихэнх нь голын гольдролын ойр орчимд үүсдэг тул тэднийг ашиглахад голуудыг сүйтгэх, ширгээх сөрөг үр дагавар гардаг.

4. Алтны нөөц хэмжээ. GFMS Thomson Reuters байгууллага дэлхийн алт үйлдвэрлэлийн талаарх 3-р улирлын тайлангаа гаргажээ. Дэлхийн улс орнуудын алт олборлолтыг энэ оны эхний улиралтай харьцуулахад 2%-иар өсч, 1507 тоннд хүрсэн байна. Өсөлтийн ихэнх хувийг ази тив эзэлж байгаа бөгөөд бүс нутгийн хэмжээнд алт үйлдвэрлэлийн өсөлтийн хэмжээ хоёр оронтой тоонд хүрсэн. Үүнд БНХАУ-ын алтны үйлдвэрлэл үлэмж нөлөөлсөн бөгөөд энэ оны 3-р улирлын байдлаар 10 орчим тонноор нэмэгдэж, нийт алт үйлдвэрлэл нь 219 тонн болжээ. Ингэснээр Хятад улс 2007 оноос хойш алт үйлдвэрлэлээрээ тэргүүлж байгаа Өмнөд африкийг гүйцэж чадлаа. Өнөөдөр алт олборлолтоор тэргүүлэгч орнуудын тоонд Хятадын араас Колумб, Орос, Австрали, АНУ, Перу, Канад улс бичигдэнэ. Гэвч АНУ, Колумби зэрэг улсуудын алт олборлолтын хэмжээ буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Бүс нутгаар авч үзвэл Индонезийн алт олборлолт 28%-иар өсч эхний хагас жилийн байдлаар 66 тонн алт олборложээ. Төв азид алтны олборлолтын хэмжээгээр хамгийн багад тооцогддог Казахстан, Киргизстан, Монгол улсын үйлдвэрлэлийн хэмжээ энэ удаад тийм ч бага байгаагүйг тайланд дурджээ.[4]. Дэлхийн улс орнуудын алт олборлолтыг 2014 оны байдлаар 1 дүгээр зурагт үзүүлэв.



1 дүгээр зураг. [12].

АНУ-ын Геологийн нийгэмлэгээс өгсөн мэдээгээр Дэлхийн газрын хөрсөн доор одоо нийтдээ 51.000 тонн алтны нөөц үлдсэн байгаа аж. Эрэлт хэрэгцээ, үнэ ханшаас нь шалтгаалаад өнөөгийн хамгийн ашиг орлого ихтэй бизнесээр алтны бизнес тодроод байна. Дэлхийн хамгийн том алтны уурхайнуудын жагсаалтыг 2011 оны байдлаар 2 дугаар хүснэгтэд үзүүлэв. [5]

Хүснэгт 2

№	Байрлал	Алт үйлдвэрлэл. кг	Ордын талбай хэмжээ.	Уурхайн төрөл
1	Папуа, Индонез Freeport-McMoRan Copper & Gold	1,444,000	527,400 акр	Ил уурхай
2	Елко, Невада Barrick Gold	1,421,000	1,081 кв/миль	Ил уурхай
3	Кажамарка, Перу Newmont Mining	1,293,000	96 кв/миль	Ил уурхай
4	Невада Veladero	1,088,000		Ил, далд уурхай
5	Сан Жуан, Аргентин	957,000		Ил уурхай
6	Клерксдорп, Өмнөд Африк	831,000	14,602 гектар	Далд уурхай
7	Карлетонвилле, Өмнөд Африк	792,000	4,188 гектар	Далд уурхай
8	Сантиаго де Чуко, Перу	770,000		Ил уурхай
9	Калгоорлие, Австрали	750,000		Ил уурхай
10	Боддингтон, Австрали	741,000		Ил уурхай

Мөн далай, тэнгисийн усанд 1 тэрбум тонн буюу 1 шоо метр усанд 3-5мг алт байдаг гэж үздэг. Гэхдээ одоог хүртэл Далайгаас алтыг олборлох аргыг нээж илрүүлээгүй байна.

Олон улсын стандартаар бол 1000 кг хүдэрт 0.5 гр алт агуулагдаж байвал эдийн засгийн хувьд үр ашигтайд тооцогддог юм байна. Гэхдээ ил уурхайнуудын хувьд ийм хэмжээний хүдэрт ихэвчлэн 1-5 гр алт агуулагддаг. Энэ агууламж бvр 30 гр хүрсэн үе бас тохиолдсон байна.

Алтны ордыг нөөц хэмжээгээр нь дараах байдлаар ангилна:

1. 100 тонноос дээш нөөцтэй үндсэн ордыг их том
2. 50-100 тонн – том
3. 10-50 тонн – дунд
4. 1-10 тонн - бага
5. 1тонн хүртэл нөөцтэй ордыг жижиг орд гэж нэрлэнэ.

Монгол орон нь алтаар баян оронд орох бөгөөд баттай, бодитой, боломжтой нөөц нь нийлээд 513970 кг гэдгийг Эрдэмтэд 2010 онд тогтоож байсан байна. Монгол нь Алтны нэг хүнд ноогдох нөөц, олборлолтоор дэлхийд тэргүүлэх байрыг эзэлдэг байна.

Геологи хайгуулын ажлаар алтны нөөцийн хувьд ирээдүй багатай гэж үзсэн талбайд хувийн хэвшлийнхэн өөрийн хөрөнгөөр хайгуул хийн, олборлох боломжит нөөц олон олборлолтын хэмжээг нэмэгдүүлсээр байна.

2011 оны нэгдүгээр сарын 1-ны байдлаар Монгол орны хэмжээнд нийт 1491.6 тонн алтны нөөцтэй бөгөөд үүнээс үндсэн ордод 1285.6тн, шороон ордод 206 тонн алт байна гэсэн тоо гарчээ. Алтны ашиглалтын тусгай зөвшөөрөл 2011.07.20-ны байдлаар 532 ширхэг олгогдсон бөгөөд үүгээр 251 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Алтны томоохон гурван орд нь тухайн судалгаанд тусгагдсанаар Оюутолгойн ордод 800 тн, Гацуурт ордод 57.9 тн, Тавт ордод 23.7 тн алт байна. [9]

Алтны үйлдвэрлэл өндөр хөгжсөн орнуудад алтны үндсэн нөөц нь ихэвчлэн үндсэн ордод 80%, шороон ордод 2 %, үдсэн нь дагалдах хэлбэрээр олборлогдсон алтанд ноогддог байна.

5. Алтны олборлолт. Монгол улсын хэмжээнд алтны анхны албан ёсны олборлолт 1900 оноос эхтэй. Орос-Манж-Монголын хамтарсан “Монголор” нэгдэл 1900-1919 онд 20 орчим тонн алт олборлосон гэсэн мэдээлэл байдаг.

Ардчилсан чөлөөт зах зээлд шилжсэнээс хойш алтны салбар огцом өссөн. Тэр үед манайх 325 хувийн инфляцитай, гадны зээл тусламж зогссон байсан тул өөрийн дотоод нөөц боломжоор эдийн засгийн уналтыг давж гарах шаардлага тулгарсан цаг. Тухайн үед алтны таамаг нөөцийг 3000 тонн гэж үзэж байсан болохоор үүнийг ашиглах хэрэгтэй гэж үзсэн.

Анхны Ерөнхийлөгч П.Очирбатын санаачлан батлуулсан “Алт” хөтөлбөр нь тухайн үед маш чухал үүрэг гүйцэтгэсэн. 1992 онд найман аж ахуйн нэгж 775,6 кг алт олборлож байсан бол “Алт” хөтөлбөрийн хүрээнд 1992-1996 онд 13,125 тонн, 1997-2000 онд 53,486 тонн алт олборлосон байна. 1992 онд алт үйлдвэрлэлийн салбарт 950 хүн ажиллаж байсан бол 2000 онд 7500 болтлоо өсчээ. Олборлолтын хажуугаар геологи, хайгуулын ажлыг ч орхигдуулаагүй байна. 1991 онд 140,49 тонн алтны нөөцтэй байсан бол 1992-2000 онд геологи хайгуулын ажлаар 110,36 тонн алтны нөөцийг нэмэн илрүүлж, 2006 онд алтны салбарын хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр дэлхийн топ 10-т орж байсан.

Тухайн үедээ алтны аж үйлдвэрийн салбар төсвийн орлого, ДНБ-ийн 20 орчим хувийг бүрдүүлж, “Алт” хөтөлбөрийн хугацаанд 107,6 сая долларыг улсын төсөвт төвлөрүүлж байжээ.

Гэхдээ энд алдаа оноо байсан. Алт хөтөлбөрийг эхлүүлж байх үед техник технологийн хүчин чадал муугаас болж хаягдал их гарсан. Хоёрдугаарт нөхөн сэргээлт хийдэггүй, дутуу хийдгээс болж байгаль орчны унаган төрхөд муугаар нөлөөлсөн. Мөн 2001 оноос “нинжа” гэсэн бүлэг гарч ирсэн. Ийм гурван янзын сөрөг үзэгдэл гарсан. [7]

Алт хөтөлбөрийн дараа “Алт-2000” хөтөлбөрийг гаргаж ирсэн нь алтны салбарын уналтыг эхлүүлсэн гэдэг. Тухайн үед алтны орлогыг нэмэгдүүлэх зорилгоор санаачилсан гэнэтийн ашгийн 68 хувийн татвар байдлыг бүр ч дордуулж, алтны олборлолт, худалдааг далд хэлбэрт оруулсан нь Монгол банкны алтны нөөцөд муугаар нөлөөлсөн. Гэтэл үүний араас байгаль орчноо хамгаалах чиглэлд “Урт нэртэй” хуулийг гаргаж ирсэн нь алтны салбарт тухайн үедээ хийж байсан алдаатай бодлогуудын үргэлжлэл болсон гэдэг. Үүний эцэст алтны салбарын толгойны өвчин болсон нинжа нар буюу хувиараа алт олборлогчид гарч ирэн байдлыг улам дордуулжээ.

2000 оноос хойш олборлосон алтны хэмжээ, үнийн өөрчлөлтийг 2 дугаар зургаар үзүүлэв.



1 дүгээр зураг. [9]

Тиймээс алтны салбар 2009 оноос унаж эхэлсэн гэж үздэг байна. Үүнээс хойш 20 тонн алт тушааж байсан үе өнгөрч Монголбанкны эрдэнэсийн сан бараг хоосрох шахжээ. Алтны тушаалт бүр хоёр тонн болон буурч байсан аж. Гэхдээ төрийн удирдлагууд Оюутолгой, Гацуурт гэх мэт том нөөцтэй, том уурхайнууд олборлолтоо эхлэхээр алт олборлолт сайжирна гэж найдаж байгаа ба монгол улсын алт олборлолтын хэтийн таамгийг 2 дугаар зурагт үзүүлсэн байдлаар төлөвлөж байна.



2 дугаар зураг. [9]

Ийнхүү алтны орлого дундарсантай холбоотойгоор Засгийн газраас нүүрс, жонш хөтөлбөрүүдийг гаргаж ирэн, алтнаас хамааралтай байсан Монгол Улс нүүрсний салбарт түлхүү ажиллах болсон юм.

Харин одоо дэлхийн зах зээл дээр алтны үнэ өсч, ирэх жилүүдэд унци алтны үнэ 1600 ам.долларт хүрэх төлөвтэй байгаа энэ үед алтны салбарыг дахин анхаарч эхэллээ. Түүнчлэн нөөц нь дууссан гэх яриаг үгүйсгэж, “Алт-3” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ярьж эхлэв. “Алт-3” хөтөлбөр өмнөх хоёр хөтөлбөрийнхөө алдаа оноог засах нь ойлгомжтой. Тиймээс ч эхнээсээ хууль эрхзүйн орчинг сайжруулж, далд хэлбэрт орсон олборлолт, тушаалтыг ил болгохоор алтны ил тод байдлыг бүрдүүлэх хуулийг санаачлан боловсруулж, хэлэлцүүлж байна.

Түүнчлэн Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг ч боловсруулан хэлэлцэж, Алтны тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах гэж байна. Энд гол нь алт олборлогч Монгол банк, арилжааны банкинд алтаа худалдсан тохиолдолд алтны нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 5% байсныг 2,5% байхаар, бусад этгээдэд худалдсан тохиолдолд 5.0 хувьтай тэнцүү байхаар хуулийн төсөлд тусгасан. Энэ өөрчлөлтөөр татварын орлого жилд 40-50 сая ам.доллараар буурах боловч алтны борлуулалтын орлого 1.5-2.0 тэрбум ам.доллараар нэмэгдэнэ.

Мөн байгаль орчин, нөхөн сэргээлт, хариуцлагатай уул уурхайн асуудлыг засч сайжруулж, алтны салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг тодруулна гэж байгаа. Хамгийн гол нь “Алт-

3” хөтөлбөр манай улсын зээлийн баталгаа болох бөгөөд дэлхийн зах зээл дээрээс бонд босгоход барьцаа болох учиртай аж.


Үүнээс гадна төгрөгийн ханшийг тогтвортой байлгахын тулд Төв банк тодорхой хэмжээний алттай байх ёстой гэдэг. Үүгээр ч зогсохгүй алт цэвэршүүлэх үйлдвэр зэрэг алтны салбарын цаашдын чиг хандлагыг “Алт-3” хөтөлбөр л тодорхойлох аж. /Алт-3 [8]/.

6. Алтны үнэ ханиш. Алт бол аль ч улс орны хувьд хамгийн эрэлттэй металл бөгөөд үнийн хэлбэлзэл нь дэлхийн эдийн засагт хамааралтай байж чаддаг ашигт малтмал юм. Өнгөрсөн оны хоёрдугаар хагаст эхэлсэн дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал аж үйлдвэрийн гол металлуудын үнэ буурахад нөлөөлж байсан боловч алтны дундаж үнэ 2011 онд 1576 ам.доллар/унц болж, 2010 оны байдалтай харьцуулахад 10%-иар өссөн байна. /1 унци = 28.349 523 грамм/

Энэ үед олон улсын Алтны үнэ судлаач дийлэнх эрдэмтэд алтны үнэ нь '2013 онд 1900\$ - 2200 \$' харин 2015 он гэхэд 3300\$ хүрнэ гэж үзэж байсан бол, харин зарим судлаачид алтны үнэ 2013 онд 1850\$ – 1950 \$ хооронд хэлбэлзнэ гэж үзэж байжээ. Гэвч Дэлхийн банкны гаргасан урьдчилсан мэдээллээр бол алтны үнэ 2013 - 2015 оны хооронд өсөж байгаад 2016 оноос буурах хандлагатай байгаа гэсэн мэдээг гаргасан байна.

Гэтэл өнөөдөр алтны дундаж үнэ 2014 оны 12-р сарын байдлаар 1202.29 ам.доллар/унци байна. [2]. Өнгөрөгч 2014 онд алтны дундаж үнэ 1271.19 ам.доллар/унци болсон нь 2013 онтой харьцуулбал 9.91%-иар буурсан үзүүлэлт болсон.

Ойрын хугацаанд Дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн байдал удаашралтай байгаагаас шалтгаалан алт, мөнгө гэх мэт үнэт металлын үнэ үргэлжлэн буурах хандлагатай байна. 2013-1014 оны алтны үнийн өөрчлөлтийг 3 дугаар зургаар харуулав.



(Эх сурвалж: www.kitco.com)

3 дугаар зураг. /үнэ ханш [2]/

Өнөөдөр Монгол банк нэг кг алтыг 67564,81 төгрөгөөр авч, 67757,041 төгрөгөөр борлуулж байна. /Алт, мөнгөний үнэ [3]/

Дэлхийн улс орнууд алтны нөөц бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн нь одоо ч хэвээр байна. worldbank.org сайт дээр 2013 оны 7 дугаар сарын байдлаар АНУ 8.1 мянган тн, Герман 2.4 мянган тн, Франц 2.6 мянган тн, Итали 2.6 мянган тн. Хятад 1.0 мянган тн, Швейцарь 1.0 мянган тн, Япон 765,2 тн алтыг банкиндаа хадгалж байна гэж мэдээлжээ. [13]

Алтны үйлдвэрлэл угаасаа ашигтай байдаг, манай улсад өнөөдөр алтны үйлдвэрлэлээс орох татвараас Монгол банкинд тушаагдах алтны хэмжээ нь илүү ач холбогдолтой байгаа тул алт баяжуулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт, үр ашгийн төсөл, тооцооны талаар мэдээлэл маш ховор байдаг юм байна. Иймд энэ талын мэдээлэл энд оруулж чадсангүй.

Ашигласан материал

1. Чөлөөт нэвтэрхий толь Википедиа <https://mn.wikipedia.org/wiki>
2. Ашигт малтмалын газрын вэб сайт. Алтны үнэ ханшийн мэдээ. <http://www.mram.gov.mn/>
3. Монгол банкны сайт.
<http://www.mongolbank.mn/dblistgoldsilverprice.aspx?vYear=2015&vMonth=12>
4. Itoim. Монгол улс алт олборлолтоороо дэлхийд тэргүүлнэ.
<http://www.itoim.mn/index.php/site/news/2583> Фотогоор авсан.
5. Дэлхийн хамгийн том алтны уурхайнууд. : news.xopom.com/12725/
6. Алтны тухай. <http://shutis-ambt.blogspot.com/2015/01/blog-post.html>
7. “Алт” хөтөлбөрийн хүрээнд 66,6 тонн алт олборложээ
<http://www.mongolianminingjournal.com/content/51668.shtml> 2013 оны 10 сарын 25
8. “Алт-3” хөтөлбөр алтны салбарыг аврах нь
<http://economics.eagle.mn/content/read/8202.htm> 2013-11-8.
9. Алтны өнөөгийн болон хэтийн төлөв графикаар.
<http://www.24tsag.mn/content/10734.shtml>
10. Алт гялалзаж байна. <http://economy.news.mn/content/116348.shtml>
11. Зарим ашигт малтмалын дэлхийн зах зээлийн үнэ, ерөнхий чиг хандлага
<http://byamba-gzobsh.blogspot.com/2014/06/2014-05-09-2.html>
12. Хэвлэл мэдээллийн алба: Яам <http://vip76.mn/content/20859>
13. Б.Нэргүй: Алтны худалдааг ил тод болгох нь улсын алтны нөөц, валютын санг нэмэгдүүлнэ. <http://news.mining.mn/mn/mn/1389238586>